

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын даргын  
2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/07  
дугаар тушаалын 19 дугаар хавсралт



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

Нийслэлийн Засаг даргын захирамж, Газрын захирлын тушаалаар байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/156 дугаар захирамж

Дагаж мөрдөх огноо: 2023.04.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2023.03.31

1. Байгууллагын нэр	2. Нэгжийн нэр
“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ Газар	Тохижилт үйлчилгээний алба
Албан тушаалын нэр: Архитектор	Албан тушаалын ангилал Зэрэглэл: ТҮ-7
Ажлын цаг: 8/40 цаг	Ажлын байрны албан ёсны байршил: Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 32-р хороо, Хүй долоон худаг
Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн	Онцгой нөхцөл: Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалын зорилго:

Хүй долоон худгийн барилга байгууламжийн зураг төслийг барилгын норм, дүрэм, стандартын дагуу гаргах, хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан байууллагын хэтийн болон ойрын төлөвлөлт хийх, албаны үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эх бэлтгэл, дизайны ажлыг хийж гүйцэтгэх.

#### Албан тушаалын зорилт:

- Хүй долоон худаг дахь хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилга байгууламж, дэд бүтэц, бүтээн байгуулалттай холбоотой зураг төслийн ажлыг зурах, төлөвлөх
- Маркетингийн албанаас зохион байгуулах үйл ажиллагааны бүх төрлийн эх бэлтгэл, загвар дизайныг боловсруулах, гүйцэтгэх
- Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах-Т Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
	1. “Монгол наадам цогцолбор”-ын		



1 дүгээр зорилтын хүрээнд	хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах барилга, байгууламж бүрт архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж батлуулах, архивлах	Хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х,Ш
	2. Байгууллагын үндсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын зураг төсөлд хяналт тавьж удирдлагуудад мэргэжлийн зүгээс тайлагнах	Тухай бүрд танилцуулж ажилласан байна.	Г,Х
	3. Барилгын эскиз зураг төсөл, материал, тооцоололлыг боловсруулах, хянан зөвшилцөх замаар төлөвлөлтийн бодлогын хэрэгжилтийг хангах	Хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х
	4. Албанаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээний бүх төрлийн дизайн, эх бэлтгэлийг шинэ, шинэлэг байдлаар цаг хугацаанд нь түргэн шуурхай хийж гүйцэтгэдэг байх.	Тухай бүрд хэрэгжилт хангагдсан байна.	Г,Т
	5. Байгууллагын ажилтнуудын ашиглавал зохих МУ-ын хууль, ЗГ-ын тогтоол, НИТХ-ын тогтоол, НЗД-ын тушаал, захирамж, журам заавар, байгууллагын даргын тушаал, байгууллагын дүрэм, дотоод журам, норм норматив, стандарт зэрэг тогтоомжийн лавлах /эрх зүйн актуудын эмхтгэл/-ийн дагуу үр дүнтэй ажиллах	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х
	6. Архитекторын сар, улирал, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан тогтсон хугацаанд тайлагнан удирдлагад танилцуулан ажиллах.	Төлөвлөгөө хугацаандаа батлагдсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Барилгын агууламж, баригдсан нөхцөл, механикийн систем нь барилгад хэрхэн нөлөөлөхийг мэддэг байх	Мэдлэг, ур чадварын хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х
	2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой төслийн зураг төсөл боловсруулах.	Хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3. Архитектур төлөвлөлт, экстерьер, интерьер, уран сайхны асуудлаар зөвлөмж, шийдэл гаргах, төлөвлөх.	Хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4. Ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой байгууллагын дарга болон албаны ахлах мэргэжилтэнгээс өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь хийж гүйцэтгэн, тайлагнаж, уялдаа холбоотой хамтран ажиллах.	Үүрэг даалгаварын биелэлт хангагдсан байна.	Г,Х
3 дугаар зорилтын	1. Ёс зүйн дүрэм сахилга хариуцлага, захирах захирагдах ёсыг баримтлан ажиллах	Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2. Удирдлагаас хариуцуулсан бусад ажлыг зохион байгуулж тайлагнах	Хэрэгжилт	Г



хүрээнд	3. Өнгөрсөн оны баримт бичгийг байгууллагын архивт цаасан болон файл хэлбэрээр хүлээлгэн өгөх	хангагдсан байна. Архивын заавар стандартад нийцсэн байна. Дүрмээр хүлээсэн үүрэг хангагдсан байна.	Г
	4. Шаардлагатай тохиолдолд сэлгэн ажиллах		
	5. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын дагуу Үндэсний их баяр наадмаар ажиллах.		Т


### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр, болон түүнээс дээш зэрэгтэй
Мэргэжил	Архитектор, барилгын инженер
Мэргэшил	Архитектор, барилгын инженер, компьютер графикийн чиглэлээр сургалтанд хамрагдсан байх
Туршлага	Мэргэжлээрээ 1-с доошгүй жил ажилласан ажилласан туршлагатай байх
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Багаар ажиллах, удирдан зохион байгуулах, манлайлах, асуудлыг түргэн шийдвэрлэх</li> <li>- Монгол хэл бичгийн зөв бичих, найруулгын мэдлэгтэй</li> <li>- Төсөл, төлөвлөгөө, тайлан, баримт бичиг боловсруулах чадвартай</li> <li>- Зурж боловсруулах, загварчлах, тооцоолох чадвартай</li> <li>- Техникийн ба дизайны шийдэл гаргах чадвартай</li> <li>- Гадаад хэлний мэдлэгтэй</li> <li>- Хэл яриа /тодорхой ойлгомжтой ярьж тайлбарлах/-ны чадвар</li> <li>- Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай</li> <li>- Компьютерийн өргөн хэрэглээний программууд ( MS Word, Excel, Power point Autocad интернэт, дотоод сүлжээний орчин дээр ажиллах чадвартай байх.</li> <li>- Байгууллагын нууц хадгалах</li> </ul>

### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалтны нэр: Газрын дарга Төхижилт үйлчилгээний албаны захирал	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, төө:  Байхгүй-	Бусад харилцах субъект:  1. Хамтран ажиллаж буй гэрээт байгууллага болон хувь хүн

### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн  <i>А.Цэнгэлсайхан</i> А.Цэнгэлсайхан	"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын Дарга   ..... С.Сайнбаяр (Тамга: 1118/699 тэмдэг, АТЗС 5751458)
2023 оны 03 дугээр сарын 31 ны өдөр	2023 оны 03 дугээр сарын 31 ны өдөр